



**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2017 оны 04 сарын 10 өдөр

Дугаар 25

Чойр

**Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд
томилогдох ажилтныг сонгон шалгаруулах
комисс байгуулах тухай**

Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 2 дугаар зүйлийн 10, 5 дугаар зүйлийн 19 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 2.2.8, 2.3.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2016 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Санхүүгийн хяналт, аудитын албаны даргыг тус тус сонгон шалгаруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

КОМИССЫН ДАРГА:

Б.САРАНТУЯА- Аймгийн ерөнхий
аудитор, салбар зөвлөлийн гишүүн

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:

М.АНХБАЯР - Төрийн захиргааны
удирдлагын хэлтсийн дарга, салбар
зөвлөлийн нарийн бичгийн дарга

ГИШҮҮДЭД:

Н.ОДОНТУЯА- Санхүү, төрийн
сангийн хэлтсийн дарга, салбар
зөвлөлийн гишүүн

Ц.ОТГОНЧИМЭГ-Төрийн захиргааны
удирдлагын хэлтсийн мэргэжилтэн

Г.ТӨРБОЛД –Төрийн захиргааны
удирдлагын хэлтсийн ажилтан

2. Сонгон шалгаруулалтыг журмын дагуу ил тод, шударга зохион байгуулж, үр дүнг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд танилцуулахыг комисс /Б.Сарантуяа/-т үүрэг болгосугай.

ДАРГА  Д.СОДНОМ





**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2017 оны 04 сарын 10 өдөр

Дугаар 26

Чойр

**Төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалд
томилогдох ажилтныг сонгон шалгаруулах
комисс байгуулах тухай**

Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 60 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 1.4.2, 4.1, “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 2.2.8, 2.3.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2016 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Нэгдсэн эмнэлэг, Нийтийн номын сан, Баянтал, Шивээговь сумдын Эрүүл мэндийн төвийн дарга, захирал, эрхлэгчдийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

КОМИССЫН ДАРГА:

С.УРАНЦЭЦЭГ - Нийгмийн бодлогын хэлтсийн дарга, салбар зөвлөлийн гишүүн

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:

Д.МӨНХЗУЛ-Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн

ГИШҮҮДЭД:

Д.МАГВАНСҮРЭН – Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, салбар зөвлөлийн гишүүн

Б.ГАНБАЯР – Мэргэжлийн хяналтын газрын дарга, салбар зөвлөлийн гишүүн

А.МЯГМАРЖАМЦ-Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн

2. Сонгон шалгаруулалтыг журмын дагуу ил тод, шударга зохион байгуулж, үр дүнг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд танилцуулахыг комисс /С.Уранцэцэг/-т үүрэг болгосугай.

ДАРГА  Д.СОДНОМ





**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2017 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 24

Чойр

Ажлын хэсгийн дүгнэлтийг хэлэлцсэн тухай

Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2, Улсын Их Хурлын 2003 оны “Журам батлах тухай” 14 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн байгууллага, төрийн жинхэнэ албан хаагч, уг албан тушаалд нэр дэвшигчийн хооронд төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх журам”-ын 1 дүгээр бүлгийн 4.3, 3 дугаар бүлгийн 15, 16, 18, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 2.2.8 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2017 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 09 дүгээр хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Баянтал сумын иргэн Ч.Энхцэцэгийн ирүүлсэн гомдлыг хянан үзээд Баянтал сумын Засаг даргын Тамгын газрын Санхүүгийн албаны дарга Чулууны Энхцэцэг нь Засгийн Газрын 2015 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 24 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 7 дугаар зүйлийн 7.5, 7.13.5, 7.13.7 дахь заалтыг тус тус зөрчиж, гүйлгээ хийхдээ байгууллагын баталгаат гарын үсэггүйгээр, байгууллагын тамга тэмдгээр гүйлгээ хийж, удаа дараа ажилдаа хариуцлагагүй хандсан, Засаг даргын Тамгын газрын дарга албан хаагчтай 2016 онд байгуулсан үр дүнгийн гэрээг дүгнэхдээ Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчтай үр дүнгийн гэрээ байгуулах дүгнэх журам”-ын 6.1-ийг зөрчсөн, Захиргааны шийдвэр гаргахдаа Захиргааны ерөнхий хуулийн 25, 26, 27, 29 дүгээр зүйлийг бүрэн хангаагүй байна гэсэн комиссын дүгнэлтийг үндэслэлтэй гэж үзсүгэй.

2. Баянтал сумын иргэн Ч.Энхцэцэгт гомдлын хариуг ажлыг 10 өдөрт багтаан хүргүүлэхийг Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга /М.Анхбаяр/-т үүрэг болгосугай.

3. Захиргааны шийдвэр гаргахдаа Захиргааны ерөнхий хууль, холбогдох дүрэм журмыг баримтлан ажиллахыг Баянтал сумын Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /В.Гантуяа/-д зөвлөсүгэй.

ДАРГА



Д.СОДНОМ



**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2017 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 28

Чойр

Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалтны нөөцөд бүртгэж, нэр дэвшүүлэх тухай

Монгол улсын Их хурлын 2003 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 13 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 32, 33, 39 дугаар заалт, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 128 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 2.3.2, 3.4, 4.4.1, Төрийн албан зөвлөлийн салбар зөвлөлийн 2017 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 10 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалтныг сонгон шалгаруулах шалгалтанд орж тэнцсэн Ч.Отгонсүрэн, Н.Алтанцэцэг нарыг удирдах албан тушаалтны нөөцөд бүртгэсүгэй.

2. Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын сонгон шалгаруулалтанд орж 73.8 оноогоор тэнцсэн Ч.Отгонсүрэн, Санхүүгийн хяналт, аудитын албаны даргын сонгон шалгаруулалтанд орж 68.95 оноогоор тэнцсэн Н.Алтанцэцэг нарыг тухайн албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлсүгэй.

3. Нэр дэвшсэн иргэдийг Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5 дахь заалтад заасан шаардлагыг хангуулан томилон ажлуулахыг аймгийн Засаг дарга /Г.Батсуурь/-д санал болгосугай.

ДАРГА  Д.СОДНОМ





**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2017 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 29

Чойр

Ц.Энхжаргалыг нөөцөөс нэр дэвшүүлэх тухай

Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 99 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийг бүрдүүлэх журам”-ын 6.2.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 2.3.5, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2017 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 10 дугаар хуралдааны шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Говьсүмбэр аймгийн Орон нутгийн өмчийн газрын хүсэлтийг үндэслэн, 2017 онд зохион байгуулагдсан төрийн албаны мэргэшлийн шалгалтанд тэнцэж, Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 65 дугаар тогтоолоор төрийн жинхэнэ албанд анх орох иргэний нөөцийн жагсаалтанд бүртгэгдсэн иргэн Цогбадрахын Энхжаргалыг Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтний орон тоонд ажиллуулахаар нэр дэвшүүлсүгэй.

2. Иргэн Ц.Энхжаргалыг нэр дэвшүүлсэн албан тушаалд томилон ажиллуулахыг Орон нутгийн өмчийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Д.Батцэцэг/-д санал болгосугай.

ДАРГА  Д.СОДНОМ





**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2017 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 30

Чойр

Ц.Уранбаярыг нөөцөөс нэр дэвшүүлэх тухай

Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5, 23.5, Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 99 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийг бүрдүүлэх журам”-ын 2.2.2, 6.2.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 2.3.5, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2017 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 10 дугаар хуралдааны шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Албан ажлын зайлшгүй шаардлагаар аймгийн Засаг даргын 2016 оны Б/19 дүгээр захирамжаар Ойн ангийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр буюу төрийн үйлчилгээний албан тушаалд томилон ажиллуулсантай холбогдуулан төрийн жинхэнэ албан хаагчийн нөөцөд бүртгэгдсэн иргэн Цогбадрахын Уранбаярыг Говьсүмбэр аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын хүсэлтийг үндэслэн, Ой, цөлжилт, биологийн олон янз байдлын асуудал хариуцсан ахлах мэргэжилтний орон тоонд ажиллуулахаар нэр дэвшүүлсүгэй.

2. Иргэн Ц.Уранбаярыг нэр дэвшүүлсэн албан тушаалд томилон ажиллуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга /Д.Мөнх-Эрдэнэ/- д санал болгосугай.

ДАРГА  Д.СОДНОМ





**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2014 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 31

Чойр

Э.Оюунбаярыг нөөцөөс нэр дэвшүүлэх тухай

Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 99 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийг бүрдүүлэх журам”-ын 6.2.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 2.3.5, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2017 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 10 дугаар хуралдааны шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Говьсүмбэр аймгийн Мэргэжлийн хяналтын газрын хүсэлтийг үндэслэн, 2017 онд зохион байгуулагдсан төрийн албаны мэргэшлийн шалгалтанд тэнцэж, Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 26 дугаар тогтоолоор төрийн жинхэнэ албанд анх орох иргэний нөөцийн жагсаалтанд бүртгэгдсэн иргэн Эрдэнэбаатарын Оюунбаярыг Мэргэжлийн хяналтын газрын Байгаль орчны хяналтын улсын байцаагчийн орон тоонд ажиллуулахаар нэр дэвшүүлсүгэй.

2. Иргэн Э.Оюунбаярыг нэр дэвшүүлсэн албан тушаалд томилон ажиллуулахыг Мэргэжлийн хяналтын газрын дарга /Б.Ганбаяр/-д санал болгосугай.

ДАРГА  Д.СОДНОМ





**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2014 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 82

Чойр

Төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтны нөөцөд бүртгэж, нэр дэвшүүлэх тухай

Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 60 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 1.4.3, 8.1.3, Төрийн албан зөвлөлийн салбар зөвлөлийн 2017 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 10 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтныг сонгон шалгаруулах шалгалтанд орж тэнцсэн Р.Солонгыг удирдах албан тушаалтны нөөцөд бүртгэсүгэй.

2. Баянтал сумын 4 дүгээр сургуулийн захирлын сонгон шалгаруулалтанд орж 66.5 оноогоор тэнцсэн Р.Солонгыг тухайн албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлсүгэй.

3. Нэр дэвшсэн иргэнийг Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5 дахь заалтад заасан шаардлагыг хангуулан томилон ажлуулахыг Говьсүмбэр аймгийн Засаг дарга /Г.Батсуурь/-д санал болгосугай.

ДАРГА



Д.СОДНОМ



**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2017 оны 04 сарын 01 өдөр

Дугаар 33

Чойр

Б.Алтантуяаг нөөцөөс нэр дэвшүүлэх тухай

Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 99 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийг бүрдүүлэх журам”-ын 6.2.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 2.3.5, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2017 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 10 дугаар хуралдааны шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Говьсүмбэр аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын хүсэлтийг үндэслэн, 2017 онд зохион байгуулагдсан төрийн албаны мэргэшлийн шалгалтанд тэнцэж, Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 65 дугаар тогтоолоор төрийн жинхэнэ албанд анх орох иргэний нөөцийн жагсаалтанд бүртгэгдсэн иргэн Бавуудоржийн Алтантуяаг Сүмбэр сумын Газрын даамлын орон тоонд ажиллуулахаар нэр дэвшүүлсүгэй.

2. Иргэн Б.Алтантуяаг нэр дэвшүүлсэн албан тушаалд томилон ажиллуулахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга /Д.Тамир/-д санал болгосугай.

ДАРГА  Д.СОДНОМ





**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
САЛБАР ЗӨВЛӨЛ**

42010 Говьсүмбэр аймаг, Чойр,
Утас/Факс: (976) 7054 3118

2017-04-21 № 44
танай _____-ны № _____-т

**Төрийн жинхэнэ албан тушаалд
томилуулах тухай**

Танай байгууллагаас ирүүлсэн төрийн жинхэнэ албаны сул орон тооны захиалгын дагуу Ой, цөлжилт, биологийн олон янз байдлын асуудал хариуцсан ахлах мэргэжилтний ажлын байранд төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэлтэй Ц.Уранбаярын нэрийг дэвшүүлэх тухай Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2017 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 30 дугаар тогтоолыг хүргүүлж байна.

Нэр дэвшсэн иргэнийг томилохдоо Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1; Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5, Эрүүл мэндийн сайдын "Төрийн жинхэнэ албанд анх орох мэргэшлийн шалгалтанд тэнцсэн иргэний эрүүл мэндийн байдлыг тодорхойлох журам"-д заасан шаардлагыг хангуулж томилохыг анхаарна уу.

Томилсон тухай шийдвэрээ 2017 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Хавсралт 1 хуудастай.

ДАРГА  Д.СОДНОМ





ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАРТ

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
САЛБАР ЗӨВЛӨЛ**

42010 Говьсүмбэр аймаг, Чойр,
Утас/Факс: (976) 7054 3118

2017.04.24 № 44
танай _____-ны № _____-т

Төрийн жинхэнэ албан тушаалд
томилуулах тухай

Танай байгууллагаас ирүүлсэн төрийн жинхэнэ албаны сул орон тооны захиалгын дагуу Сүмбэр сумын газрын даамлын ажлын байранд төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэлтэй Б.Алтантуяагийн нэрийг дэвшүүлэх тухай Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2017 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 33 дугаар тогтоол, холбогдох баримт бичгийг хүргүүлж байна.

Нэр дэвшсэн иргэнийг томилохдоо Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5, Эрүүл мэндийн сайдын "Төрийн жинхэнэ албанд анх орох мэргэшлийн шалгалтанд тэнцсэн иргэний эрүүл мэндийн байдлыг тодорхойлох журам"-д заасан шаардлагыг хангуулж томилохыг анхаарна уу.

Томилсон тухай шийдвэрээ 2017 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Хавсралт 13 хуудастай.

ДАРГА  Д.СОДНОМ





**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2017 оны 04 сарын 25 өдөр

Дугаар 34

Чойр

**Ажлын хэсгийн дүгнэлтийг
хэлэлцсэн тухай**

Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2, Улсын Их Хурлын 2003 оны “Журам батлах тухай” 14 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн байгууллага, төрийн жинхэнэ албан хаагч, уг албан тушаалд нэр дэвшигчийн хооронд төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх журам”-ын 1 дүгээр бүлгийн 4.3, 3 дугаар бүлгийн 15, 16, 18, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 2.2.8 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2017 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 09 дүгээр хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Баянтал сумын иргэн Д.Эрдэнэцэцэгийн ирүүлсэн гомдлыг хянан үзээд 2015 онд баталсан ажлын байрны тодорхойлолтонд ажлын байранд тавигдах мэргэжлийн шаардлага хэсэгт Эрх зүйч болон бусад мэргэжил байхаар тусгасан байсныг 2017 онд шинэчлэн боловсруулж Эрх зүйч мэргэжил байхаар тусган өөрчилсөн нь тухайн ажлын байрны шаардлагыг хангаж Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2015 оны 56 дугаар тогтоолоор тухайн албан тушаалд нэр дэвшин томилогдсон Д.Эрдэнэцэцэгийг ажлын байрны тодорхойлолтонд тавигдсан шалгуур үзүүлэлтийг хангаагүй гэж үзэх үндэслэл болохгүй бөгөөд Ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, батлахдаа Төрийн албаны зөвлөлийн 2004 оны 34 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Ажлын байрны тодорхойлолтыг боловсруулах заавар”-ын боловсруулах хэсгийн 1.11, баталгаажуулах хэсгийн 1.в, 2 дахь заалтыг тус тус зөрчсөн, Удирдлагаас өгсөн үүрэг, даалгаврын биелэлтийг хугацаанд нь тайлагнаагүй, хариуцлагагүй хандсан, ажлын байрны тодорхойлолтонд заагдсан үүргийг зөрчсөн гэсэн үндэслэлээр Д.Эрдэнэцэцэгт Засаг даргын Тамгын газрын даргын 2017 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/05 дугаар тушаалаар сахилгын шийтгэл ногдуулсантай холбоотойгоор Д.Эрдэнэцэцэгийн зүгээс хуулийн хугацаанд ямар нэгэн гомдол гаргаагүй нь ажилдаа хариуцлагагүй хандсан гэсэн үндэслэлийг хүлээн зөвшөөрсөн гэж үзэх үндэслэлтэй, Засаг даргын Тамгын газрын даргын тушаал, Засаг даргын захирамжийг эрх зүйн үндэслэл, утга найруулгын хувьд илтэд алдаатай төлөвлөдөг гэх боловч зөвшөөрлийн хуудсаар захирамж, тушаалын төслийг холбогдох албан тушаалтнууд хянан, гарын үсэг зурж, Засаг дарга, Тамгын газрын даргад танилцуулагдан хянагдсанаар албажин гарах эрхтэй болж, эрх бүхий албан тушаалтан захирамж, тушаал дээр гарын үсэг

зурж, тамга, тэмдэг дарсанаар баталгааждаг бөгөөд эрх зүйн актыг баталгаажуулсан эрх бүхий албан тушаалтан эцсийн хариуцлагыг хүлээдэг тул Д.Эрдэнэцэцэгт тухайн асуудлын хувьд хариуцлагыг дангаар хүлээлгэх үндэслэл байхгүй, тушаалд дурьдагдсаныг нотлох боломжгүй, Засаг даргын Тамгын газрын даргын “Эрдэнэцэцэгийг үүрэгт ажлаас нь халах тухай” 2017 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн Б/11 дүгээр тушаалыг гаргахдаа Захиргааны ерөнхий хуулийн 25, 26, 27, 29 дүгээр зүйлийг бүрэн хангаагүй байна гэсэн комиссын дүгнэлтийг үндэслэлтэй гэж үзсүгэй.

2. Баянтал сумын иргэн Д.Эрдэнэцэцэгт гомдлын хариуг ажлыг 10 өдөрт багтаан хүргүүлэхийг Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга /М.Анхбаяр/-т үүрэг болгосугай.

3. Захиргааны шийдвэр гаргахдаа Захиргааны ерөнхий хууль, холбогдох дүрэм журмыг баримтлан ажиллахыг Баянтал сумын Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /В.Гантуяа/-д зөвлөсүгэй.

ДАРГА  Д.СОДНОМ





**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2017 оны 12 сарын 03 өдөр

Дугаар 12

Чойр

Г Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн Г
шалгалтын ярилцлагын ажлын хэсэг байгуулах тухай

Төрийн албаны зөвлөлийн 2013 оны “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам, заавар батлах тухай” 86 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-ын 5.6, 7.2.3, 7.4 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн 2017 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 03 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Нутгийн захиргааны байгууллагын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэдээс мэргэшлийн шалгалтын ярилцлага авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

АЖЛЫН ХЭСГИЙН ДАРГА:

Д.МАГВАНСҮРЭН – Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, салбар зөвлөлийн гишүүн

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:

М.АНХБАЯР – Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга, салбар зөвлөлийн гишүүн

ГИШҮҮД:

Г.УРАНЧИМЭГ – Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газрын дарга, салбар зөвлөлийн гишүүн

2. Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтын ярилцлагыг журмын дагуу ил тод, шударга зохион байгуулахыг ажлын хэсэг /Д.Магвансүрэн/-т үүрэг болгосугай.

ДАРГА  Д.СОДНОМ

